МЭДЭЭ · 2022 оны 9-р сарын 26

АВЛИГЫН 12 ГЭМТ ХЭРГИЙГ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛҮҮЛЭХЭЭР ШИЛЖҮҮЛЛЭЭ



Прокурорын байгууллага өнгөрсөн долоо хоногт буюу 2022 оны 9 дүгээр сарын 19-нөөс 23-ны өдрүүдэд мөрдөн байцаалтын 2486 хэрэгт хяналт тавьж, 267 хэргийг яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлж шийдвэрлэлээ.

Тодруулбал, Эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 154, Өмчлөх эрхийн эсрэг 89, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 36, Авлигын 12, Амьд явах эрхийн эсрэг 11, Бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг 11, Хүрээлэн байгаа орчны эсрэг 5, Мөнгө угаах 2, Татвар төлөхөөс зайлсхийх, Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах гэмт хэрэг тус бүр 1-ийг шүүхэд шилжүүлсэн байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1937